ЦАХИМ ЖОРООР ОЛГОХ ЗААВАР

- Цахим жор ирэх үед гараас **F10** товчийг дарна. Энэ үед доорхи цонх нээгдэнэ.
- О) Жорын дугаар, Регистрийн дугаар талбарт зургаан оронтой жорын дугаарыг болон Даатгуулагчийн регистрийн дугаарыг хамтад нь оруулаад Enter товчийг дарна. Энэ үед жорын мэдээлэл гарч ирнэ.



- Эхлээд Худалдааны нэр талбарт зарах гэж буй эмээ сонгоно. Таны зарсан эм энд сонгосон эмтэй ижил байх ёстой. Үгүй бол Нийт үнэ, Нийт даатгалын хэмжээ буруу гарч та хүнээс буруу төлбөр авахыг анхаарна уу!
- 2) **Тоо хэмжээ** талбарт эмчийн бичсэн тоо хэмжээ ширхэгээрээ харагдаж байна. Үүнийг өөрчлөх боломжгүй.
- 3) F4. Баркод талбарт зарж барааныхаа баркодыг уншуулна. Энэ үед Эмийн нэр талбарт уншуулсан эмийн нэр гарч ирнэ. Хэрэв гарч ирэхгүй бол таны баркод системд бүртгэлгүй байна гэсэн үг. Энэ үед та Эмийн нэр талбарт эмийн нэрээ бичиж оруулах ёстой. Дараа нь баркодоо дахин уншуулна. Анхаар: Баркод зөв байх ёстой. Учир нь цахим жорын систем таны эмийг баркодоор нь танихаар хийгдсэн. Тиймээс баркод буруу бол систем автоматаар жорыг хүчингүй болгохоос гадна огт баркодгүй эмийг жороор олгох боломжгүй болсон!
- 4) F5. Эмийн нэр талбарт таны зарахаар уншуулсан эмийн нэр харагдана. Баркод уншуулах үед өөрөө гарч ирнэ. Гэхдээ баркод бүртгэлгүй бол та энд эмийн нэрээ гараар бичиж оруулна. Дараа нь баркодоо дахин уншуулахыг анхаарна уу.
- 5) Тоо хэмжээ талбарт таны уншуулсан эмийн бодит тоо хэмжээ харагдана. Хэрэв таны тооцооноос өөр тоо байвал та шууд гараар засах ёстой. Энд байгаа тоо хэмжээгээр таны үлдэгдлээс хасагдана гэдгийг анхаарна уу! Тиймээс та тухайн эмийн зарах үнийг хайрцгаар нь оруулсан бол энд хайрцгийн тоо хэмжээ байх ёстой. Жишээ нь Виферон лааг эмч 10 ширхэгээр бичсэн байлаа гэж бодьё. Харин таны зарах үнэ 23000 буюу хайрцгаараа байгаа бол тоо хэмжээгээ 1.000 гэж оруулна.
- 6) Нийт үнэ талбарт цаанаасаа буюу цахим системээс ирсэн үнэ харагдана. Энэ үнээс хэтрүүлж зарах боломжгүй гэдгийг анхаарна уу! Харин багасгаж болно. Хэрэв таны зарах үнэ илүү хямд бол, эсвэл эмчийн бичсэн тооноос цөөн ширхэгээр зарж байгаа бол Нийт үнийг гараараа багасгана. Хэд болгохоо та өөрөө тооцоолно.

Нийт үнэ хэтрүүлсэн тохиолдолд жорыг хүчингүй болно гэдгийг анхаарна уу!

7) Нийт даатгал талбарт даатгалаас хөнгөлөх нийт дүн нь эмчийн бичсэн тооны дагуу харагдана. Зурагт үзүүлснээр 10 ширхэг виферон лааны нийт даатгал нь 13200 юм байна. Хэрэв та эмчийн бичсэнээс цөөн ширхэгээр зарж байгаа бол **Нийт даатгал**ыг багасгах ёстой. Ингэхдээ та өөрөө тооцоолж гараараа багасгаж бичнэ. Тооцоолохдоо **Даатгал** талбар дахь утгыг ашиглана (Зураг 10 –р заасан байна). Энэ талбарт ширхэгийн даатгал харагдаж байгаа.

- 8) Нийт авах дүн талбарт үйлчлүүлэгчээс авах дүн харагдана. Энэ талбар өөрөө бодогдоно.
- 9) Дээд үнэ талбарт цаанаас өгөгдсөн ширхэгийн зарах үнэ харагдана.
- 10) Даатгал талбарт цаанаас өгөгдсөн ширхэгийн даатгал харагдана.
- 11) **F2. Төлөх** товчийг дарж борлуулалтаа хийнэ. Энэ үед сугалаатай баримт автоматаар хэвлэгдэж жорын мэдээлэл автоматаар цахим системрүү илгээгдэнэ.
- 12) Даатгалын дээд үнээр зарах бол сонго талбарыг сонгосон үед та эмээ цаанаас ирсэн дээд үнээс хэтрүүлж зарах боломжгүй. Харин энэ талбарын сонголтыг болиулбал та өөрийн зарах үнээр борлуулалт хийх боломжтой болно. Гэхдээ дээд үнэ хэтрүүлсэн тохиолдолд жор хүчингүй болох аюултайг анхаарна уу!
- 13) **Нэхэмжлэх дүн шалгах** товчийг дарж тухайн сард нийт хэдэн жор өгсөн, даатгалаас нэхэмжлэх дүн нь хэд болж байгаа зэргийг шалгаж харна. Энд мөн илгээгдээгүй жор байгаа эсэхийг шалгаж дахин илгээнэ.

Түгээмэл асуулт ба хариултууд

Жор дээр хоёр эм байгаа боловч нэгийг нь хүн авахгүй бол яах вэ?

- Зөвхөн авсан эмийг нь уншуулаад аваагүйг нь хоосон орхино. "Нийт авах дүн" талбар өөрчлөгдөхгүй байх нь хамаагүй. "Төлөх" товчоо дарах үед таны уншуулсан эмд харгалзах авах дүн л харагдана.
- Тоо хэмжээ буруу гараад байна?
 - Зарж буй эмээ уншуулах үед програм таны тоо хэмжээг бодож харуулдаг. Гэхдээ энэ нь зөв байх албагүй бөгөөд хэрэв буруу бол та өөрөө гараараа засах ёстой. Засахдаа энд бичигсэн тоо хэмжээгээр таны үлдэгдлээс хасагдана гэдгийг анхаарна уу!

Нийт үнэ хөдлөхгүй байна?

 "Нийт үнэ" нь цаанаас ирсэн дээд үнийг эмчийн бичсэн тоогоор үржүүлсэн дүн юм. Хэрэв та эмчийн бичсэнээс цөөн тоогоор зарах эсвэл танай үнэ илүү хямд бол "Нийт үнэ" –г гараас засах боломжтой. Хэд болгож засахаа та өөрөө тооцоолно.

Нийт даатгал хөдлөхгүй байна?

 "Нийт даатгал" нь цаанаас ирсэн даатгалыг эмчийн бичсэн тоогоор үржүүлсэн дүн юм. Хэрэв та эмчийн бичсэнээс цөөн тоогоор зарж байгаа бол түүндээ тааруулж "Нийт даатгал" –г гараас засах ёстой. Хэд болгож засахаа та өөрөө тооцоолох ба "Даатгал" талбарын утгыг харж байгаад тооцоолно уу.

– Сарын төсөв буюу лимит хэтэрсэн эсэхийг яаж мэдэх вэ?

- Цахим жор бүртгэх цонх нээлттэй байх ёстой. Хэрэв үгүй бол F10 дарж нээнэ. Уг цонхны зүүн доод булангаас "Нэхэмжлэх дүн шалгах" товчийг дарна.
- Энэ үед "Цахим жорын жагсаалт" цонх нээгдэнэ. Шүүлтийн огноо талбарт хугацаагаа оруулаад Дуудах товчийг дарна. "Даатгалаас нэхэмжлэх" баганын хөл дүнг та өөрийн сарын төсөвтэйгээ харьцуулж шалгана.
- Цахим жорын жагсаалт цонх дээр хэрэв зарим жорын илгээсэн огноо талбар хоосон байвал илгээгдээгүй гэсэн үг бөгөөд зүүн дээд булангаас "Цахим жорын системрүү багцаар илгээх" товчийг дарж бөөнд нь илгээнэ.